

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

1999 оны 09 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

Журмыг шинэчлэн найруулж
батлах тухай

Компанийн тухай шинэ хууль, Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. Компанийн тухай хуульд нийцүүлэн “Нийтэд санал болгосон хувьцааны захиалга авах тухай” журмыг хавсралтад дурдсанаар шинэчлэн найруулж баталсугай.
2. Хорооны 1995 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцааны захиалга авах тухай журам”-ыг хүчингүйд тооцсугай.
3. Журмын энэхүү өөрчлөлтийн талаар нийтэд таниулах, мэдээлэхийг Ажлын алба /Ж.Жадамбаа/, Хөрөнгийн бирж /О.Батбилэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

НИЙТЭД САНАЛ БОЛГОСОН ХУВЬЦААНЫ ЗАХИАЛГА АВАХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1 .Нээлттэй хувьцаат компани шинээр үүсгэн байгуулахаар нийтэд санал болгож хувьцааны захиалга авахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР.Хувьцааны захиалга авах тухай

2.1. Нээлттэй хувьцаат компанийг үүсгэн байгуулагчид нь шинээр компани үүсгэн байгуулах төсөл боловсруулна.

2.2. Компани үүсгэн байгуулах төсөлд дор дурдсан зүйлийг тусгана :

- 1) эрхлэх үйл ажиллагааны чиглэл;
- 2) хувь нийлүүлсэн хөрөнгийн төлөвлөсөн хэмжээ;
- 3) хувьцаа гарган төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт, зарцуулалтын тооцоо;
- 4) төлөвлөсөн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийн тооцоо;
- 5) зарлах хувьцааны төрөл, тоо, нэрлэсэн үнэ;
- 6) шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа;
- 7) хувьцааны загвар.

2. 3. Хувьцааны захиалга авах үйл ажиллагааг зохион байгуулж хувьцааны захиалга авах этгээдийг үүсгэн байгуулагчийн хурлаас томилно.

2. 4. Үүсгэн байгуулагчийн хурлаас томилсон захиалга хүлээн авагч нь үүсгэн багуулах төсөл, гаргах хувьцааны төрөл, хэлбэр, нэрлэсэн үнэ, захиалга хүлээн авах газар, захиалга эхлэх, дуусах хугацаа, захиалга хүлээн авагчийн ажиллах цагийн хуваарь зэргийг нийтэд мэдээлнэ.

Захиалга хүлээн авагч нь захиалагчид шинээр компани үүсгэн байгуулах төсөл, түүнд холбогдох үндсэн баримт бичгүүдтэй бүрэн танилцах боломж олгох үүрэгтэй.

2. 5. Хувьцааны захиалга авахдаа энэхүү журмын хавсралт-маягт №А4-1, маягт №А4-2, маягт №А4-3-ыг ашиглана.

2. 6. Хөрөнгө оруулагчид шинээр үүсгэн байгуулах компанийн нийтэд санал болгон гаргах хувьцааг худалдан авах саналаа “Захиалгын хуудас”-аар /маягт №А4-1, маягт №А4-2/ өгнө.

Захиалагч нь хуулийн этгээд бол маягт №А4-1-ийг, иргэн бол маягт №А4-2-ыг ашиглах захиалга хүлээн авна.

2. 7. Захиалга авах хуудас дараах бүрдүүлбэртэй байна:

- 1) захиалга хүлээн авагчийн нэр, хаяг
- 2) захиалагчийн нэр, хаяг
- 3) захиалагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хувьцаа захиалахыг зөвшөөрсөн эрх бүхий дээд байгууллагын шийдвэр;
- 4) захиалагч нь иргэн бол иргэний үнэмлэх /паспорт/-ийн дугаар, регистрийн дугаар;
- 5) захиалж байгаа хувьцааны төрөл, тоо ширхэг, үнийн дүн;
- 6) захиалсан хувьцааны төлбөр хийх хугацаа, журам, нөхцөлийн тухай тэмдэглэл;

- 7) захиалгын биелэлтийн тухай тэмдэглэл;
- 8) захиалга өгсөн, авсан этгээдийн гарын үсэг, тэмдэг;
- 9) захиалга өгсөн, захиалсан хувьцааны төлбөр хийсэн огноо.

2. 8. Захиалгын хуудсыг дугаарласан байх бөгөөд хуудсыг үндэслэн “Захиалгын дэвтэр” /маягт №А4-3/-т бүртгэнэ.

2. 9. Захиалгын хуудаст захиалагч хуулийн эрх бүхий төлөөлөгч, иргэн, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсанаар захиалга хийсэнд тооцно.

2. 10. Захиалгын хуудсыг 3 хувь үйлдэх бөгөөд өнгөн хувийг захиалга хүлээн авагчид, хоёр дахь хувийг захиалгчид өгнө. 3 дахь хувийг Үнэт цаасны хороонд ирүүлэх баримт бичигт хавсгана.

2. 11. Хувьцааны захиалгыг үнэт цаасны болон андеррайтерийн компаниар дамжуулан авч болно. Энэ тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон захиалга хүлээн авагч нь үнэт цаасны компанитай гэрээ байгуулна.

ГУРАВ. Захиалгын төлбөр хийх

3. 1. Захиалагч нь захиалсан нийт хувьцааны үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх төлбөрийг захиалгын хугацаа дууссанаас хойш ажлын 30 хоногийн дотор хийнэ.

3. 2. Захиалсан хувьцааны төлбөрийг мөнгөөр, үүсгэн байгуулагчийн зөвшөөрснөөр эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж болно.

3. 3. Захиалагч мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд үүсгэн байгуулагчийн шаардлагаар санал болгож байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийнхээ үнийн талаар үнэлгээний байгууллага болон холбогдох мэргэжлийн шинжээчдийн дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

3. 4. Мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд захиалга авагч нь хөрөнгө оруулагчийн санал болгосон тухайн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнэ, үнэлгээний байгууллага, мэргэжлийн шинжээчийн дүгнэлт зэргийг үндэслэн төлбөрт тооцох үнийн талаархи саналаа үүсгэн байгуулагчийн хуралд танилцуулна.

3. 5. Мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийж байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийг үүсгэн байгуулах хуралд орлцогчид санал нэгтэй шийдвэрлэнэ.

3. 6. Хувьцааны төлбөрийн мөнгө болон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, үюуны өмчийг хүлээн авах, баримтжуулах журмыг үүсгэн багуулагчийн хурлаар тогтооно.

3. 7. Тогтоосон журмын дагуу мөнгөн, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийг хүлээн авснаар хувьцааны төлбөрийн урьдчилгаа хийсэнд тооцно.

3. 8. Захиалгын хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор төлбөр хийсэн хувьцааны үнийн дүн нь 10 саяд хүрсэн бол нээлттэй хувьцаат компани байгуулагдах нөхцөл бүрдсэн гэж үзнэ.

3. 9. Нээлттэй хувьцаат компани байгуулагдах дээр заасан нөхцөл бүрдсэн үед үүсгэн байгуулагчийн хурлыг зарлан хуралдуулж Компанийн тухай хуульд заасан журмын дагуу нээлттэй хувьцаат компанийг улсын бүргэлд бүртгүүлнэ.

3. 10. Нээлттэй хувьцаат компани нь бүртгэх байгууллагад бүртгүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор Хорооны 1999 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн тогтоолоор батлагдсан “ Нийтэд санал болгож гаргасан үнэт цаасыг бүртгүүлэхийг зөвшөөрөх тухай” журмын дагуу Үнэт цаасны хороонд бүртгүүлэх өргөдөл гаргана.

ДӨРӨВ. Үүсгэн байгуулагчдийн үүрэг хариуцлага

4. 1. Үүсгэн байгуулагч нь нийтэд санал болгон хувьцаа гаргаж шинээр нээлттэй хувьцаат компани байгуулах тухай төсөл боловсруулах, хувьцааны захиалга авах хугацаа

журмаа нийтэд сурталчлах, хувьцааны захиалга авах ажиллагааг зохион байгуулах, үүрэг хүлээж төсөлд дурдсан үзүүлэлт, холбогдох баримтын үнэн зөвийг хариуцна.

4. 2. Хувьцааны захиалгыг энэ журамд заасны дагуу авч, төлбөрийг цаг хугацаанд нь хийлгэх, хувьцааны төдбөрт тооцёон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн болон үюуны өмчийн үнийг үндэслэлтэй тогтоох асуудлыг үүсгэн байгуулагчид хариуцна.

4. 3. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар компани байгуулагдаагүй бол захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг үүсгэн байгуулах хурал товлосон өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор нөхөн олох үүргийг үүсгэн байгуулагчид хүлээнэ.

ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

Маягт №А4-1

Хувьцааны захиалгын хуудас

_____ аймаг /нийслэл/-ийн байгуулах гэж
байгаа компанийн нэр _____

Захиалга авсан _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ мин

1. Захиалагч байгууллагын нэр

- Оноосон нэр
- Оршин байгаагаар
- Харилцах данс

3. Захиалсан хувьцааны төрөл

Тоо ширхэг.....
Нэрлэсэн үнэ.....
Нийт үнэ.....

4. Захиалга хийхийг зөвшөөрсөн эрх барих дээд байгууллагын шийдвэрийн дугаар, огноо
/шийдвэрийн хуулбарыг
хавсаргана/.....
.....

5. Захиалгын төлбөр хийх хэлбэр хугацаа _____
нөхцөл _____

6. Захиалгын төлбөр хийх хугацааг сунгасан.....
эсэх, тэмдэглэл.....

7. Захиалгын биелэлт /төлбөрийн баримтыг хавсаргана/

8. Захиалга эс биелсэн тохиолдолд урьдчилсан төлбөрийг буцаан олгосон сар, өдөр

Худалдан авах захиалга өгсөн байгууллагын дарга
/тэмдэг/ _____
/гарын үсэг/
Захиалга авсан хувьцаа гаргахыг хүсэгч
_____ /гарын үсэг/

Маягт №А4-2

Хувьцааны захиалгын хуудас

_____ аймаг /нийслэл/-ийн байгуулах гэж
байгаа компанийн нэр _____

Захиалга авсан _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ мин

1. Захиалагч хувь хүний овог, нэр

2. Паспортын сери, регистрийн дугаар.....

- Оршин сууга газрын хаяг.....

- Харилцах утас.....

3. Захиалсан хувьцааны төрөл

Тоо ширхэг.....

Нэрлэсэн үнэ.....

Нийт үнэ.....

4. Захиалгын төлбөр хийх хэлбэр

хугацаа _____

нөхцөл _____

5. Захиалгын төлбөр хийх хугацааг сунгасан эсэх

6. Захиалгын биелэлт /төлбөрийн баримтыг хавсаргана/

7. Захиалга эс биелсэн тохиолдолд урьдчилсан төлбөрийг буцаан олгосон сар, өдөр

Худалдан авах захиалга өгсөн

хувь хүний гарын үсэг

Захиалга авсан хувьцаа гаргахыг хүсэгч

.....
.....
/гарын үсэг/

Хувьцааны захиалга авах тухай
журмын 3 дугаар хавсралт

Маягт №А4-3

Хувьцааны захиалгын бүртгэл

Захиалга хүлээн авагчийн нэр

| № | Захиалга | | | Хувьцаа гаргагчийн нэр |
|---|-----------------|--------------------------------|------|------------------------------|
| | Албан ёсны хаяг | Паспорт гэрчилгээний дугаар | Утас | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

| Захиалга өгсөн хугацааны бүртгэл | | | | |
|----------------------------------|-----|------|-----|-----|
| он | сар | өдөр | цаг | мин |
| 6 | 7 | 8 | 9 | 10 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

| Авах хувьцааны захиалга | | | | Захиалга авсан хүний албан тушаал, гарын үсэг |
|-------------------------|-----|-----|----------|---|
| Төрөл | Тоо | Үнэ | Нийт үнэ | |
| 11 | 12 | 13 | 14 | 15 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |